

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

IX АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Миний хайрт хараацай

Манай зуслангийн муу хар байшин хаягдсанаас хойш хэдэн жил ч өнгөрөв дөө. Уул нь хааш яаш цавчсан хар модон дүнз зааж шинэсний холтос давхарлан хучсан, газар шалтай, хойд ханандаа ганц онигор гэгээвчтэй онгойх хаагдахдаа орилон гиншдэг хаалгатай, гаднаасаа хорин жил бороонд угаагдаж хувхайрсан дотроосоо хорин жил утаанд утагдаж харласан гэлээ ч салхи шуурганд салгалан чичирдэггүй, аадар бороонд нэвтэрдэггүй, найдвартай нь аргагүй байшин сан. Тэр навтгар байшингийн хананд миний нааж байсан чихрийн цаас, аавын цахиур бууны өлгүүр, хар модон дүнзний ан завсар, ноён нуруун дээрх шувууны баас одоо хүртэл нүдэнд илхэн үзэгдэнэ.

Би тэр жил зуслангийнхаа буурийг үзээд ер нь айлын буурь арилдаггүйг гайхсан юм. Үгүйдээ л шарилж ургана. Эрүүл газар агь ганга ургаж байхад айлын бууринд шарилж л ургана.

Төрсөн газар, бага балчир нас, өнгөрсөн зовлон жаргалаа мартаж үл чадах хүний үр садад гэрийн буурь шиг тэмдэгтэй газар ховор бололтой.

Тэр жил зуслангийн буурийг үзэхэд зуны сүүлээр модожсон лууль, шарилж, ийш тийш хазайсан хэдэн хар шон, эжий арьс утдаг агсан нүхнээс өөр юм байсангүй. Тийн бага балчир насаа дурсан санаж суутал манайхтай цуг зусдаг байсан хоёр хараацай санаанд орж билээ. Миний арваад настай байхад тэр хоёр сэргэлэн гоо жигүүртэн манай навтгар байшингийн яс модонд үүр зассан юм. Бусад хараацайн ангаахайнууд дэгжих ойртсон хойно манайд ирж үүрээ зассаныг бодоход өөр газар зассан үүрээ сүйтгүүлсэн бололтой байв. Тэр хоёр ойрх горхины эргээс өдөржин шавар зөөж, хагд өвс, хялгас ноосоор торлон наасаар хоёр гурван хоногт уран хийцтэй бат бэх үүр барилаа.

Тэр хоёр үүрээ барьж дуусаад хэд хоног үзэгдэхээ болив. Бодвол шувууныхаа хэргээр л явсан байлтай. Би гадуур нисэх олон хараацай дотор манай хоёр яваа болов уу гэж хардаг боловч тэр олон адилхан амьтдыг ялгах аргагүй. Нэг өглөө харсан чинь цайвар цээжтэй тас хар жигүүртэй хараацай үүрэн дотроо их л ядарсан шинжтэй нүдээ аниад бөмбийн сууж байв. Үүрний хажууд улаан хүрэн цээжтэй уртавтар чамбай биетэй нөгөө хараацай сууж цаадхаасаа ямар нэг юм асуух мэт энхрий зөөлнөөр дуугарч байв. Цайвар цээжит үүрнээсээ хэд хоног холдсонгүй. Өлсөж цангадаггүй юм болов уу гэж би их гайхна. Гэтэл нэг харж байсан чинь улаан цээжит хараацай тэмээлзгэнэ зууж ирээд нөгөөдхийнхөө аманд хийж байв. Тэгэхээр нь би бас амандаа ус балгаж ирээд уулгадаг байх нь гэж ойлгоод өхөөрдөн баярлав. Шувуу ус балгаад нисэж чаддаг гэж итгэхдээ их нээлт хийсэн юм шиг олзуурхаж байж билээ.

Нэлээд хэдэн хоног өнгөрсөн хойно нэг өглөө тэдний үүр дотор жийв жийв гэсэн дорой дуу сонстоход өнгийж харвал шар хошуутай, судас шөрмөс нь гүрдийсэн халцгай хөх биетэй таван сохор ангаахай шахцалдан хэвтэж байв. Бусад хараацай аль хэдийн дэгдээхэйнүүдээ дагуулан нисэж явахад ийм хожуу гарсан амьтад яана даа гэж бодмоор байв. Гэвч тэр тав гайхмаар амархан бойжиж билээ. Хэд хоног өнгөрөхөд нүцгэн биед нь хараацайн өнгө ялгасан ноолуур ургаж, өдөржин идэх юм нэхэж биеэсээ томоор ангайлдан чих дүйртэл орилолдож байх болов. Хоёр хараацай хорхой шавж зууж зай завсаргүй нисэн ирэхэд ангаахайнууд нь ам амнаасаа булаалдаж байгаад л дор нь үгүй хийж орхино. Зуны дундуур тэр хэд хоорондоо зодолдох, үүрнээсээ гарч суух болж нэг өдөр эх эцэг хараацайгаа дагаад манай навтгар байшингаас гарч одлоо. Анхандаа шөнө орой болохоор үүрэндээ буцаж ирдэг байснаа сүүлдээ бүр байчхав. Гадаа хорооны шургааг дээр тавуулаа суугаад шулганалдаж байх нь их хөөрхөн.

Ингээд хараацайн нэг өнөр гэр бүл манайхтай хамт амьдрах болсон мэт санагдаж байж билээ. Гэтэл дараа жилийн зун нөгөө хоёр хараацай зүсээрээ буцаж ирсэн бөгөөд харин таван дэгдээхэй нь ирсэнгүй. Бодвол нэгэнт том хараацай болоод тус тусынхаа үүрийг засахаар явсан хэрэг биз ээ. Тэр хоёр хараацай манайхтай дөрвөн жил хамт зусав. Би тэдэнд их хайртай болж билээ. Гэсэн ч өд сөдөө ургахаар үүрээ орхиод явдаг хараацайн дэгдээхэйтэй адил би ч гэсэн төрсөн гэр орон аав ээжээ орхиод алс газар явлаа.

Ингээд олоон жилийн дараа зуслангийн бууриа үзэж хэчнээн дурсан харамсавч өнгөрсөн юм өнгөрдгийг бодож манай муу навтгар байшин хараацайн үүртэй хамт алга болсон ч нөмөрт нь хоргодож өссөн хүний үр, хараацайн дэгдээхэй амьд мэнд бөгөөд

өөрсдөө бас шинэ байшин, шинэ үүр барьж яваа гэхээс амьдрал гэдэг төгсгөлгүйн тухай санаашран бодсон юм.

Даалгавар 1. Зохиолч эхэд ямар асуудлыг дэвшүүлсэн бэ? 2 оноо

Зохиолчийн дэвшүүлсэн асуудал:

.....

.....

.....

.....

Даалгавар 2. Эхийн гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож байгаагаа эхээс эш татан, өөрийн үгээр тайлбарлаарай. (3 оноо)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:

.....

.....

.....

Тайлбар:

.....

.....

.....

Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо баримтад үндэслэн илэрхийлж, өөрийн санааг дүгнэн бичье.

Даалгавар 3. Дэвшүүлсэн асуудлын талаар үзэл бодлоо бичээрэй. Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан, тодорхой, бодитой, асуудалтайгаа уялдаа холбоотой байхад анхаараарай. 2 оноо

Миний үзэл бодол:

.....

.....

.....

.....

Даалгавар 4. Өөрийн үзэл бодлоо үнэ цэнтэй, чухал гэдгийг батлах, дэмжих баримтуудыг бичээрэй. 3 оноо

Баримт 1:

.....

.....

Баримт 2:

.....

.....

Баримт 3:

.....

.....

Засагч багш нарт:

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1.5, 2.5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 2 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсон бол 2 оноо

Эхэд дэвшүүлсэн гол асуудлыг олоогүй ч тодорхой хэмжээнд хөндсөн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудалтай хамаагүй зүйл олсон эсвэл асуудлыг тодорхойлоогүй тухай гэж ерөнхийлсөн бол 0 оноо /Цөөхөн үлдсэн мазаалайг хамгаалах тухай гэх биш мазаалайн тухай эм хариулт нь ерөнхий болно/

Даалгавар 2. Нийт 3 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Эхээс эш татан санаагаа батлан тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл эхээс эш таталгүй, өөрийн үгээр бичсэн бол 0 оноо

Даалгавар 3. Нийт 2 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай уялдаа холбоотой бол 1 оноо

Үзэл бодол нь дэвшүүлсэн асуудалтай холбоо хамааралгүй бол 0 оноо

Үзэл бодлоо илэрхийлэх үгсийг ашигласан бол 1 оноо

Үгсийг ашиглаагүй бол 0 оноо /Мөн даалгавар 1-ийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 3/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 4. Нийт 3 оноо

Даалгавар 3-т бичсэн үзэл бодолтой хамааралтай бол 1 оноо

Ахин нэг өөр байр сууринаас хандсан бол 0 оноо /хэрэв энд 0 оноо авсан бол баримтыг зөрчилтэйд тооцно/

Өөрийн үзэл бодлыг дэмжсэн, баталсан буюу зөрчилгүй бол 1 оноо

Аль нэг баримт зөрчилтэй бол 0 оноо /өөрийн үзэл бодлын эсрэг, ташааруулж болох, худал зэрэг баримтууд нь зөрчилтэйд тооцогдоно/

Гурван баримт бичсэн бол 1 оноо

Нэг л баримт дутуу бол 0 оноо /Мөн даалгавар 1, 3-ыг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 4/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо/

Даалгавар 5. Нийт 3 оноо

Даалгавар 3, 4-ийг хамааруулан нэгтгэн дүгнэсэн бол 1 оноо

Дүгнэлт нь тодорхой бөгөөд ойлгомжтой бол 1 оноо

Дүгнэлтээс асуудлыг шийдэх ямар нэгэн шийдэл, гарах арга зам эсвэл шинэ санаа гарсан бол 1 оноо

Дээрх шалгуурын аль нэгийг хангаагүй тохиолдолд харгалзах оноог хасна. Мөн даалгавар 1, 3, 4-ийн аль нэгийг гүйцэтгэлгүй орхиж энэ даалгавар /Даалгавар 5/-ыг хийсэн бол энэ даалгаврыг бүхэлд нь 0 оноо

Даалгавар 6. Нийт 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг бүрэн төгс зассан бол 2 оноо

Өгүүлбэрийн найруулгын алдааг дутуу хагас зассан бол 1 оноо

Найруулгын алдааг засаагүй, буруу зассан эсвэл өөр шинэ алдаа гаргасан бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

Бүгдийг зөв хөрвүүлсэн бол 5 оноо

1-2 үг алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

3-4 үг алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

5-6 үг алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

7-8 үг алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

9 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулаа	оноо өгөх заавар	ОНОО
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж, эхийг бүхэлд нь учир шалтгааны уялдаа холбоотой бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо, цаг хугацаа, үйл явдлын дараалал бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч сэдвийн дагуу бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл нэг үйл явдлыг биш хэд хэдийг бичсэн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Дүр дүрслэл	Дүр, дүрслэлийг оновчтой ашигласан бол	2
	Оновчтой биш ч дүрслэх ур маяг ашигласан бол	1
	Дүрслэх ур маяг ашиглаагүй, хүний хэлсэн үг зэрэг нь ялгарч мэдэгдэхээргүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэв маяг	Эх бүхэлдээ хүүрнэсэн өнгө аястай бол	2
	Эхийн ихэнх хэсэг хүүрнэсэн бол /дүр, орчноо танилцуулах гээд хэт их тоочих зэрэг алдаа гарсан бол/	1
	Эх бүхэлдээ өөр хэв маягтай бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй бол	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	180-210 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X